



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 11 өдөр

Дугаар 6/20

Хэрлэн сум

Д.Жамбааг ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 64 дүгээр зүйлийн 64.1, 78 дугаар зүйлийн 78.2, дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өндөр насны тэтгэвэрт гарахтай холбогдуулан ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан Батноров сумын Засаг дарга Д.Жамбааг 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн сумын Засаг даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.
2. Сумын Засаг дарга шинээр томилогдох хүртэл Засаг даргын бүрэн эрхийг Засаг даргын орлогч Б.Ган-Эрдэнээр хэрэгжүүлсүгэй.
3. Төрийн албанд 32 жил ажилласан Д.Жамбаад хуульд заасан 12 сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн мөнгөн тусламж олгохыг Батноров сумын Засаг даргын Тамгын газрын дарга А.Борчулуунд зөвшөөрсүгэй.
4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хянагч тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Ганбаатарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ